
ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ БУЛШНЫ БҮТЭЦ, ОЛДВОР, ХОЛБОГДОХ ОН ЦАГ, ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Г.Эрэгзэн*

Гарчиг

- I. Оршил
 - II. Хүннүгийн язгууртны булшны хэлбэр, бүтцийн онцлог
 - III. Хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн олдвор
 - IV. Хүннүгийн язгууртны булшны бүтэц ба олдворын харьцуулалт
 - V. Хүннүгийн язгууртны булшны холбогдох он цаг
 - VI. Үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн Хүннүгийн язгууртны
булш бий болсон нөхцөл ба он цагийн таамаглал
 - VII. Дүгнэлт
-

* Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн захирал, доктор/Ph.D/

Товчлол :

Хүннүгийн язгууртны том булшийг Оросын эрдэмтэн П.К.Козловын экспедиц Монголын Ноён уулын дурсгалт газарт анх малтан судласнаас хойш бараг 100 жил өнгөрсөн бөгөөд энэ бүх үеийн туршид Хүннүгийн язгууртан дээд давхаргад холбогдох том булштай 13 дурсгалт газраас Бор булгийн ам, Хялгант, Овооно хар, Оргойтон зэрэг 4 газарт малтлага судалгаа хийгдээгүй, бусад 9 газарт судалгаа шинжилгээний ажил хийгдсэн байна. Одоогоор нийт 28 язгууртны том булшны малтлага судалгааг Монгол болон Өвөр Байгал, Тувагийн нутагт хийжээ. Мөн Дуурлиг нарс, Гол мод-II, Бэлхийн ам зэрэг 3 газарт судалгааны ажил ид хийгдэж байгаа юм.

Тус өгүүлэлд өнөөг хүртэл малтлага судалгаа хийсэн Хүннүгийн язгууртны булшны хэрэглэгдэхүүнийг хамруулан булшны бүтэц зохион байгуулалтын онцлог, илэрсэн олдвор эд өлгийн зүйлсийн харилцан хамаарлын талаар авч үзэхийн зэрэгцээ үйлдвэрлэсэн цаг хугацаа нь тодорхой олдвор хэрэглэгдэхүүн болон дээжийн радио-карбон задлан шинжилгээний үр дүнд тулгуурлан булшны холбогдох он цагийн хязгаарыг тогтоож, түүнд үндэслэн Хүннүгийн үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн том хэмжээт язгууртны булшнууд бий болсон цаг хугацаа, нөхцөл байдлын талаар өгүүлэхийг зорив. Өөрөөр хэлбэл энэ өгүүлэлээр Хүннүгийн язгууртан дээд давхаргын том хэмжээт булшны хувьсал өөрчлөлтийн асуудлыг хөндөхийг зорьсон юм.

■ Түлхүүр үг ■

Хүннү, язгууртны булш, том хэмжээт булш, үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булш

I . Оршил

НТӨ IV зууны үеэс одоогийн Монгол болон Өвөр Монголын нутагт Ху хэмээх нүүдэлчин аймаг оршин амьдарч, үе үе Хятадын нутагт довтлон сандаргадаг байсан талаар Нанхиадын бичгийн сурвалжуудад олонтаа дурьдсан байдаг. Ху нарын хойчис Модун шаньюйн үед буюу НТӨ 209 онд тал нутгийн нүүдэлчин овог аймгуудыг нэгтгэн нэг захиргаанд оруулж, Евроазид нүүдэлчдийн анхны эзэнт гүрнийг байгуулсан бөгөөд харамсалтай нь тэднийг өнөөгийн бид хятад бичгийн сурвалжид доромж утгаар тэмдэглэсэн “Хүннү” гэдэг нэрээр мэдэх болсон билээ.

Хүннүчүүд тал нутгийн нүүдэлчдийг нэгтгээд зогсохгүй НТӨ 200 онд Хятадын Хан улсад довтлон Пинчэн боомтын орчимд эзэн хаан Лю Баныг их цэрэгтэй нь бүслэн буулгаж авсан ба Дундад Азид нэвтэрч Торгоны замын дагуух хот улсуудыг өөртөө нэгтгэснээр тухайн үеийнхээ хамгийн хүчирхэг улстөрийн хүчин болж чаджээ. Тиймээс ч бүс нутгийн түүхэнд тэдний оролцоо, нөлөө харьцангуй их байсан нь тодорхой бөгөөд тухайн цаг үеийн Евроази төдийгүй Хятадын түүх-соёлын асуудлыг судлахад ч Хүннү нь орхигдуулахын аргагүй чухал сэдэв болсоор ирсэн юм.

Хүннүг анх хятадын бичгийн сурвалжийн мэдээнд тулгуурлан судлаж байсан ч эдгээр бичиг баримтууд нь хэт нэг талыг барьж бичигдсэн тул алдаа мадагтайн дээр тэдний жинхэнэ ахуйг судлахад хэрэг болохуйц хангалттай мэдээллийг агуулж байсангүй. Тохиолдолоор XX зууны эхэнд Өвөр Байгалаас олон тооны чулуун дарааст жижиг булшнууд, Монголоос Ноён уулын том булшнууд илэрч олдсоноор Хүннү нарын соёлын өв бодитоор оршин байгаа нь мэдэгдэж ихээхэн анхаарал татаж эхэлжээ.

Өнгөрсөн хугацаанд Хүннү нарт холбогдох хот суурины үлдэгдэл, булш оршуулга, хадны сүг зураг зэрэг археологийн дурсгалууд олон газраас илэрч судлагдан тэдний ахуй амьдралын талаар ихээхэн мэдээллийг өгсөн юм. Тэр дундаа булш оршуулгаас олдсон олдворууд нь Хүннүгийн эдийн соёлыг судлахад маш чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүнд тооцогдож байна.

Одоогийн байдлаар Монгол улсын нутаг болон ОХУ-ын Буриадын БНУ, Тувагийн БНУ, БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО, Шинжан-уйгарын ӨЗО, Хөхнуур муж зэрэг өргөн уудам нутгаас Хүннү нарт холбогдох 15 мянга гаруй булш оршуулгын дурсгал илэрч мэдэгдээд

байна. Эдгээр булшийг ерөнхийд нь язгууртны болон жирийн жижиг хэмээн ялгаж үзэх бөгөөд язгууртны булшнууд нь хэмжээний хувьд харьцангуй том, газрын хөрсөн дээр ил товойн харагдах шороон овоолготой, түүний захаар чулуу өрж хашсан дөрвөлжин хэлбэрийн байгууламжтай, өмнө талдаа трапец хэлбэрийн урт үүдэвчтэй байдгаар цагариг хэлбэрийн жижиг булшнуудаас эрс ялгардаг.

Язгууртан дээд давхаргынханд холбогдох том хэмжээтэй булш бүхий Ноён уул, Гол мод, Гол мод-II, Дуурлиг нарс, Бор булгийн ам, Тахилтын хотгор, Сэлбийн ам, Хялгант, Овооно хар зэрэг 9 оршуулгын газар Монгол улсын нутагт оршин байна. Харин Ильмийн ам (Сүүж), Царам, Оргойтон зэрэг язгууртны булш бүхий 3 дурсгал Буриадын БНУ-ын нутаг Өвөр Байгалаас, Бай Даг-II хэмээх язгууртны булштай газар Тувагийн БНУ-ын нутгаас илэрч судлагджээ.

Дээрх 13 оршуулгын газарт байгаа язгууртны булшны тоо харилцан адилгүй юм. Тухайлбал, Ноён уулын дурсгалт газарт нийт 230 гаруй булш бүртгэснээс 60 орчим [Полосьмак и др 2008, рис 1, 2], Гол модны дурсгалт газарт 418 булш бүртгэснээс 180 орчим [Ерөөл-Эрдэнэ 2015, 42], Гол мод-II дурсгалт газарт 200 гаруй булш байгаагаас 108 [Эрдэнэбаатар нар 2002, 3-р зураг], Дуурлиг нарсны дурсгалт газарт 250 гаруй булш бүртгэснээс 80 орчим [Дэвсгэр зургийг 2010 онд зохиогчийн оролцсон экспедиц шинэчлэн хийсэн], Бор булгийн аманд 140 гаруй булш байгаагаас 50 орчим [A report ...'Gurvan gol' 1994], Тахилтын хотгорт 140 гаруй булш байгаагийн 30 орчим [Баярсайхан, Эгиймаа 2008, 1-р зураг], Сэлбийн аманд 10 булш байгаагийн 6 нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэртэй язгууртны булш [Амартүвшин нар 2009, дэвсгэр зураг]-нууд байна¹⁾. Харин Ильмийн аманд байх 300 гаруй булшны 14 [Kononov 2008, Pl 2], Царамд буй 20 булшны 5, Оройтонд байх 18 булшны 4, Тувагийн Бай Даг-2 дурсгалт газарт байгаа 16 булшны 5 нь язгууртны үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булш болох нь мэдэгдэнэ. Эндээс үзвэл одоогоор тодорхой мэдэгдэж байгаа Хүннүгийн 15 мянга гаруй булшнаас 530 гаруй буюу 30/1 орчим нь язгууртны булш болж байна. Өөр нэг сониролтой статистик үзүүлэлт нь нийт олдсон язгууртны булшны 96 орчим хувь нь Монгол улсын нутагт, үлдэх 4 хүрэхгүй

1) Дээрх оршуулгын газруудад буй язгууртны булшийг нарийн тоолсон бүртгэл байхгүй тул дурьдсан бүтээлүүдэд хэвлэгдсэн дурсгалт газрын дэвсгэр зургийн тэмдэглэгээг тоолох байдлаар тоймлон гаргав.

хувь нь ОХУ-ын нутагт байх бөгөөд Ильмын ам, Царам, Оройтон, Бай Даг-II зэрэг дурсгалууд бүгд Монголтой хиллэх хилийн бүсэд байрлана.

Хүннүгийн язгууртны булшийг анх Ноён уулын дурсгалт газарт П.К.Козловын удирдсан шинжилгээний анги 1924 онд малтан шинжилснээс хойш зуу орчим жилийн хугацаанд дээрх 13 дурсгалт газраас Бор булгийн ам, Хялгант, Овооно хар, Оргойтон зэрэг 4 газарт судалгаа хийгдээгүй, харин бусад 9 газарт язгууртны булшны малтлага судалгааны ажил хийгдэж, нийт 28 булшийг малтан шинжилсэн байна. Одоогийн байдлаар Дуурлиг нарс болон Бэлхийн ам, Гол мод-II зэрэг дурсгалт газарт язгууртны булшны малтлага судалгааны ажил үргэлжилж байна.

Тус өгүүлэлд сүүлийн үеийн судалгааны үр дүнд тулгуурлан Хүннүгийн язгууртны булшны бүтэц зохион байгуулалтын онцлог, олдвор эд өлгийн зүйлсийн харилцан хамаарал, холбогдох он цаг болон үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булш бий болсон цаг хугацаа, ийм хэлбэрийн булш байгуулах болсон нөхцөл байдлын талаар зохиогчийн таамаглалыг танилцуулахыг зорив.

II. Хүннүгийн язгууртны булшны хэлбэр, бүтцийн онцлог

Монгол болон Өвөр Байгал, Тувагаас олдсон Хүннүгийн язгууртны булшнууд нь гадаад, дотоод хэлбэрийн хувьд ихээхэн нийтлэг болох нь мэдэгдэж байна. Тухайлбал, булшнууд газрын өнгөн хөрсөн дээр ил цухуйсан дөрвөлжин хэлбэрийн намхан шороон дараас овоолготой, түүний гадуур хашсан маягаар өрж тавьсан чулуун хүрээтэй бөгөөд бүгд өмнө талдаа трапец хэлбэрийн урт үүдэвчтэй юм. Дотоод байгууламж буюу газрын гүнд байх хэсэг ч ерөнхийдөө төстэй дээрээс доош багасган шатлаж ухсан гүнзгий нүхний ёроолд дүнзээр зааж хийсэн том модон хашлагатай, түүн дотор гоёмсог хийцийн модон авсанд хүнээ тавьж, дагалдах эд өлгийн зүйлсийг тогтсон дэг жаягийн дагууд байрлуулсан байдаг. Дор язгууртны булшны бүтцийг гадаад болон дотоод байгууламжид хуваан дэлгэрүүлэн авч үзье.

Гадаад байгууламж. Дээр өгүүлсэнчлэн Хүннүгийн язгууртны булш нь газрын өнгөн хөрсөн дээр ил цухуйсан гадаад байгууламжтай бөгөөд түүнийг ерөнхийд нь нүхний чанх

дээр байгуулсан гол (үндсэн) ба түүний өмнө талд залгуулан үйлдсэн үүдэвч гэсэн 2 хэсэгт хуваах боломжтой байна. Гол хэсэг нь дөрвөлжин, тэгш өнцөгт хэлбэртэй бол үүдэвч нь хойд тал өргөн, өмнө тал нарийн трапец хэлбэртэй юм. Гол хэсэг болон үүдэвчны захаар тойруулж хашсан маягаар чулуу өрсөн байдаг. Нэг сонирхолтой зүйл нь Гол модны 20-р булсныхтай адил зарим булшны гол байгууламж болон үүдэвчний төвийг дайруулан хойноос өмнө тийш уртааш нэг эгнээ, зүүнээс баруун тийш хэд хэдэн эгнээгээр чулуу өрж нэмэлт байгууламж хийсэн нь тохиолддог [Ерөөл-Эрдэнэ, Гантулга 2008, 150]. Дийлэнх булшны нүхэн дотроос үүнтэй төстэй хэд хэдэн үе чулуун өрлөг илэрдэг бөгөөд зарим булшинд үүнийг чулуугаар бус модоор хийсэн байх нь бий. Тиймээс энэхүү өрлөг нь булшны гадаад байгууламжтай холбоотой гэхээс илүүтэй нүхийг булах үед хийгдсэн зүйл бөгөөд зарим булшинд газрын хөрсөн дээр ил харагдаж, заримд нь ажиглагдахгүй байгаа нь ч үүнтэй холбоотой бололтой.

Малтлагын хэрэглэгдэхүүнээс ажиглахад үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булшны гол байгууламж (уртын хэмжээг баримтласан) бага нь 5-8 м, дундаж нь 10-20 м, том нь 30 гаруй метр хэмжээтэй байна. Түүнээс гадна Гол мод-II дурсгалт газарт малтлага судалгаа хийсэн 1-р булш (гол байгууламж 48х42 м, үүдэвч нь 37.5 м урттай), Дуурлиг нарсны дурсгалт газарт судалгаа хийж буй 160-р булш (үүдэвчний хамт нийт урт нь 88 м), Гол модонд цэвэрлэгээ хийсэн 61-р булш зэрэг хэт том булшнууд олон томоохон дурсгалт газруудад цөөн тоотой тохиолддог.

Дотоод байгууламж. Хүннү булшны дотоод байгууламж буюу газар доорх бүтцийг үндсэнд нь булшны нүх болон оршуулгын хэсэгт хувааж үзэх боломжтой юм.

Хүннүгийн язгууртны булшны нүх их гүнзгий байдаг онцлогтой. Хамгийн гүехэн нь Тахилтын хотгорын 64-р булсных 5.5 м гүн [Баярсайхан, Эгиймаа 2008, 188] бол Дуурлиг нарсны 5-р булсных 7 м, 2-р булсных 8 м, 1-р булсных 15 м, Царамын 7-р булшны нүх 17 м, Ноён уулын 20-р булшны нүх 18 м, Гол модны 20-р булсных 18.3 м, Гол мод-II дурсгалт газрын 1-р булшны нүхний гүн 22 м хүрсэн нь хамгийн гүнд тооцогдож байна [Эрэгзэн нар 2011, 2015; Miniaev, Sakharovskaia 2006, 49; Цэвээндорж нар 2007, 290; Ерөөл-Эрдэнэ 2015, 50; Эрдэнэбаатар нар 2015, 33]. Ийм гүнзгий нүхийг ухахад нарийн төлөвлөж ухахаас өөр арагүй юм. Анх булш хийхэд ухсан нүхний заагийг ажиглаж чадсан

Ноён уулын 20-р, 24-р, Дуурлиг нарсны 1-р, 2-р, 5-р язгууртны булшнуудын нүхийг бүгдийг дөрвөлжин хэлбэрээр дээрээс доош шатлан жижгэсгэх маягаар нарийн тооцоолж ухсан нь мэдэгдэж байна. Жишээлбэл, Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн хээрийн шинжилгээний анги 2006-2007 онд малтлага хийсэн Дуурлиг нарсны 2-р булшны нүх 8 м гүн бөгөөд өнгөн хөрсний доорх 1-р үе нь 10х8 м хэмжээтэй 2 м гүн, 2-р үе нь 9х7 м хэмжээтэй 2 м гүн, 3-р үе нь 8х6 м хэмжээтэй 1.5 м гүн, 4-р үе нь 7х5 м хэмжээтэй 2.5 м гүн юм. Үе тус бүрийг 0.5 м өргөнтэй шатласан байсан. Мөн гадаад байгууламжийн захын 3 үе чулуун хүрээг 1-р үеийн нүхний ирмэгийг дагуулан тавьсан байв [Эрэгзэн нар 2008, 158]. Үүдэвчийг ерөнхийд нь өмнө талын үзүүрээс эхлүүлэн нүхний гол хэсэг тийш налуулан гүнзгийлэх байдлаар ухжээ. Үүдэвч ихэвчлэн оршуулгын модон байгууламжийн дээд хэсэг хүртэл үргэлжлэх ба нүхийг ухахад шороо гаргахаар бэлтгэсэн зам болох нь малтлагын явцад практик байдлаар батлагдсан. Мөн оршуулгын үед ч түүгээр эд өлгийн зүйлсийг нүхэнд зөөж оруулахад ашиглах давхар ач холбогдолтой байсан бололтой байдаг.

Оршуулгын хэсэг буюу нүхний ёроолд дүнз, захалсан бүдүүн шургаагаар зааж хийсэн модон хашлага байрлуулсан байна. Ийм модон хашлага дан болон давхар 2 хэлбэр мэдэгддэг. Үүнээс дан хашлага нь авсны гадуур хүрээлсэн хайрцаг маягтай 4 хана, тагтай бөгөөд хэмжээгээр харьцангуй жижиг юм. Тахилтын хотгорын 1, 2-р [Наваан 1999], 64-р [Баярсайхан, Эгиймаа 2008] булш, Дуурлиг нарсны 2-р, 5-р булш [Эрэгзэн нар 2008; 2009] зэрэг харьцангуй жижиг хэмжээтэй булшнууд дан модон хашлагатай байв. Тахилтын хотгорын 64-р булшны хашлага 2.6х1.2 м хэмжээтэй бол Дуурлиг нарсны 2-р булшных 3.6х1.9 м, Тахилтын хотгорын 1-р булшны модон хашлага 4х1.8 м хэмжээтэй юм.

1-р хүснэгт. Хүннүгийн язгууртны булшны гадаад, дотоод байгууламжийн хэмжээс

№	Дурсгалт газар/ Булшны дугаар	Гадаад байгууламжийн хэмжээ					Хашлагын хэмжээ		Нүхний гүн
		Урт	Өргөн	Өндөр	Үүдэвч				
					Урт	Өргөн	Гадаад	Дотоод	
1	Гол мод-II, 1-р булш	48	42	3,7	37.5	22х8	8х5	-	22
2	Ноён уул, Баллод	35	35	3.5	9.4	10.8х8	5.87х3.8	4.27х2.14	-
3	Гол мод, 20-р булш	34	31.5	1	23	14х4	4.4х2.94	3.45х2.1	18.3
4	Гол мод, 1-р булш	34	26	1.6	36	15х6	5.4х4.4	-	16
5	Царам, 7-р булш	32	32	1	20	-	6.1х4.2	4.1х2.4	17

№	Дурсгалт газар/ Булшны дугаар	Гадаад байгууламжийн хэмжээ					Хашлагын хэмжээ		Нүхний гүн
		Урт	Өргөн	Өндөр	Үүдэвч		Гадаад	Дотоод	
					Урт	Өргөн			
6	Ноён уул, Кондратьевын булш	26	26	1.3	17.5	-	5.32x3.71	3.75x2	-
7	Ноён уул, 6-р булш	24.5	24.5	1.95	22.5	9.2х	5.34x3.99	3.31x2.23	-11.03
8	Дуурлиг нарс, 1-р булш	23.5	22	1.5	32	14x3	4.7x3.2	3.4x2.6	15
9	Ноён уул, 1-р булш	21.9	21.9	1.73	21	9x4.5	4.61x2.9	3x1.55	-10.1
10	Ноён уул, 20-р булш	19	18	1	17	9x3	4.8x3.2	-	18.35
11	Ильмийн ам, 54-р булш	19	18	1.5	14	8x2	3.9x2.2	-	8.5
12	Ноён уул, 23-р булш	19	17	1.4	17.5	8.2x5	4.31x3	2.98x2	-10.2
13	Ноён уул, Симуковын булш	17	15	-	14	5х	-	-	
14	Ноён уул, 24-р булш	16	14	1.5	12	5х	4.1x2.7	3.16x1.65	9/-7/
15	Тахилт, 1-р булш	16	13	-	-	-	4x1.8	дан	12-
16	Тахилт, 2-р булш	16	13	-	8	-	3.4x1.5	дан	11-
17	Ноён уул, Доржсүрэнгийн булш	14	14	1.1	10	8x3	-	Дан	-7
18	Гол мод, 79-р булш	12	10	0.4	8	4x2.5	3х.1.7	дан	7
19	Дуурлиг нарс, 2-р булш	11	9	0.4	15		3.6x1.9		8
20	Дуурлиг нарс, 5-р булш								
21	Тахилт, 64-р	8.27	7.8	0.4	7.1	3.3x1.75	2.6x1.2	дан	5.5

Давхар хашлага гэдэг нь дан хашлагын гадуур дүнзээр зангидан дөрвөлжин хана босгож, түүнийгээ мөн дүнзээр тагласан байгууламж болно. Ноён уулын 6-р булшаар жишээ татвал, гадаад хашлагын баруун зүүн талын хана 5.34 м урт, хойд өмнө тал 4 м өргөн, ханыг 7 ш бүдүүн дүнзээр зааж хийсэн тул өндөр нь 1.98 м хүрч байжээ. Гадаад хашлагыг 20 гаруй дүнзийг хөндлөн тавьж тагласан байна. Дотоод хашлагын урт 3.31 м, өргөн 2.23 м, өндөр 1.66 м ба дотоод хашлага ч тусдаа тагтай аж. Түүнийг гадаад хашлагын өмнөд хананд шахаж байгуулсан тул 2 хашлагын хооронд(баруун зүүн болон хойт талд) хүн багтахуйц хонгил үүссэн байна. Энэ хонгилын хойт тал 0.98 м, зүүн баруун тал 0.64-0.75 м өргөн ажээ [Руденко 1962, 19].

Давхар хашлага голчлон гадаад байгууламжийн хана 20 м-с урт том булшнуудад тохиолддог. Гол мод-II дурсгалын 1-р булш [Эрдэнэбаатар нар 2015, 35], Ноён уулын Баллодын булш [Доржсүрэн 1961; Руденко 1962], Гол модны 1-р, 20-р булш [Эрдэнэбаатар, Ерөөл-Эрдэнэ 2001; Ерөөл-Эрдэнэ 2015, 51], Царамын 7-р булш [Miniaev, Sakharovskaia 2006] зэрэг гадаад байгууламжийн хэмжээ 30 м-с дээш гарах том булшнуудын гадаад хашлагын хананы урт 5 м-с илүү гарч байна. Харин гадаад байгууламжийн хана 16 м урттай харьцангуй жижиг булш

болох Ноён уулын 24-р булш [Доржсүрэн 1961]-ны гадаад хашлага хамаагүй бага буюу 4.1х2.7 м хэмжээтэй байв.

III. Хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн олдвор

Малтлага судалгаа хийсэн язгууртны бүх булш эрт цагт тонуулчдын гарт өртөж сүйтгэгдсэн байдгаас ихэнх үнэ цэнэтэй олдвор эд өлгийн зүйлс үгүй болж, оршуулгын хэсэг ихээхэн сандаачигдсан байдаг. Хэдий тийм ч булшинд тонуулчид хэрэгсэлгүй орхисон, эсвэл золоор тэдний нүдэнд өртөж гарт таараагүй зарим зүйлс үлдэж хоцрох агаад эдгээрт тулгуурлан булшны оршуулгын хэсгийн зохион байгуулалтыг сэргээн төсөөлөх боломж гардаг. Язгууртны булшнаас малтлагаар олдсон олдвор эд өлгийн зүйлс нь хийц, хэлбэр, зориулалтын хувьд ихээхэн нийтлэг болох нь ажиглагдах ба тэдгээрийг булшинд тавьсан байрлал ч ойролцоо болох нь мэдэгддэг. Тухайлбал, хамгийн жижигт тооцогдох Тахилтын хотгорын 64-р, Дуурлиг нарсны 5-р булшнаас бусад язгууртны булшны модон хашлагын таг дээр Хан хийцийн морин тэрэг тавьж, түүний хойт талд олон адуу малын ясыг хойлголосон байв. Хүннүгийн язгууртны булшнаас ихэвчлэн 1 сүйх тэрэг болон түүний хэсгүүд илэрч байсан. Харин Гол мод-II дурсгалын 1-р булшнаас илэрсэн тэрэгний төмөрлөг тоногнууд нь багаар бодоход 15-17 тэрэгний хэсгүүд болох нь судалгааны явцад тодорхой болжээ [Эрдэнэбаатар нар 2015, 116]. Язгууртны булшнаас илэрсэн тэрэг нь ихэвчлэн хар, улаан өнгийн чий будагтай гоёмсог хийцтэй байсан ба 2 дугуйтай ёслолын тэрэгний үлдэгдэл болох нь мэдэгддэг. Одоогоор Чихэртийн зоо хэмээх дурсгалт газарт малтлага хийсэн хүннүгийн булшнаас л 4 дугуйтай сүйх тэрэгний үлдэгдэл илэрсэн байна [Эрэгзэн нар 2020].

Модон хашлагын дотор талд алт, мөнгө, хүрэл чимэг хадан чимэглэсэн модон авсанд хүнээ хэвтүүлж хашлагын голд юмуу аль нэг тал руу шахан тавих бөгөөд авсан дотор болон түүний ойр орчмоос гоёмсог хийцийн хүзүүний зүүлний хэсгүүд олддог нь талийгаачийн хүйсээс үл хамааран чимэг зүүсгэл дагалдуулдаг байсныг харуулна. Мөн хувцас өмсгөлд хадах алтан болон алт шармал хүрэл морины дүрст чимгүүд ч авсны ойролцоогоос их олджээ. Ноён уулын 1-р, Дуурлиг нарсны 2-р, Гол модны 1-р булшнаас диск хэлбэрийн дугуй хаш, ромбо буюу жишүү дөрвөлжин, хавирган саран, соёо хэлбэрийн хаш эдтэлүүд илэрсэн бөгөөд

эдгээр нь Дорнын орнуудад ихээхэн дэлгэрсэн оршуулгад хэрэглэх тусгай зориулалтын чимгүүд²⁾-тэй төстэй байгаа нь Хүннүд ч хашаар хүний биед байх нүх сүвүүдийг бөглөж, цээжин дээр нь диск хэлбэрийн нүхтэй хашийг тавьж сүнсийг тэнгэрт гарахыг бэлгэддэг зан үйл байсныг илтгэх баримт юм. Гол мод-II дурсгалын 1-р булшнаас илэрсэн ганц эвэрт домгийн амьтны дүрслэлтэй диск хэлбэрийн хаш эдлэл [Эрдэнэбаатар нар 2015, 149] хамгийн ур хийц сайтайгаар алдартай болжээ.

Модон хашлагын шаланд Ноён уулын 6-р булшнаас бүтнээр олдсонтой ижил араатан амьтдын тулалдаж буй дүрсийг зээглэн хадсан эсгий ширдэг дэвсэх ба ханыг торго нэхмэлээр бүрж засдаг байна. Ханыг бүрсэн торго нэхмэл дээр утас ороон хээ, дүрс хатгасан агаад Ноён уулын 6, 25-р булшнаас сайн хадгалалттай олдсон бөс нэхмэл дээрх хүний хөргүүд, морьтой дайчдын дүрс зэрэг нь Хятад, Солонгост их дэлгэрч байсан чулуун бунханы ханын зурагтай төстэй байдлаар хашлагын дотор талыг засч дэглэсэн байжээ гэх сэтгэгдлийг төрүүлдэг. Өөрөөр хэлбэл, энэ нь хашлагын ханыг бүтээсэн бөс нэхмэл дээр чулуун бунхант булшны хананд нас барагчийн өнгөрсөн ба хойд насны амьдралыг харуулсан зураг зурсан байдагтай ижил утга агуулга бүхий дүрсийг утсаар хатгаж урласан гэх таамаглал юм [Эрэгзэн 2004]. 2006 онд Ноён ууланд малтсан 20-р булшнаас морь унан давхиан дундаа эрчээрээ зугтан буй буга гөрөөсийг нум сумаар харваж байгаа байдлыг үзүүлсэн дүрслэлийг өнгийн утсаар хатгасан нэгэн нэхмэлийн тасархай олдсон нь Когурё болон Хятадын Зүүн хойд нутагт ихээхэн дэлгэрсэн чулуун бунханы ханын зургийн гол дүрслэл болох “ан агнуур”-ын зурагтай туйлын төстэй бөгөөд энэ нь бидний дээрх таамаглалыг илүү баталж өгсөн.

Авсны гадна хойт тал болон давхар хашлагын хоорондох завсараас тахил тайллагын идээ ундаа хийж тавьсан шавар ваар, чий будагтай аяга, таваг зэрэг олон төрөл, хэлбэрийн сав суулгын зүйлс олддог. Шавар ваарнууд нь ерөнхийдөө жижиг булшнаас олддогтой ижил нарийн хүзүү, дэлбэгэр амсартай бутан болон задгай амсартай хотго хэлбэртэй байх ч жижиг булшнаас гардаггүй 1 м орчим өндөр онцгой том хэмжээтэй, ёроолоос дээх нь хуруу

2) Дорнын орнуудад эртнээс хашийг шидтэй хэмээн итгэдэг байснаас оршуулж буй хүний амыг жирхэрээ цохны хэлбэрт хаш, нүдийг модны навчны хэлбэрт хашаар таглаж, хоёр гарт гахайн хэлбэрт хашийг атгуулах ба цээжин дээр голдоо нүхтэй дугуй хавтгай хашийг тавьж, чих хамрын нүх, хойт сүв зэргийг гонзгой хэлбэрийн хашаар бөглөдөг өвөрмөц заншил байжээ. Энэ нь нас барсан хүнийг дахин төрж элбэг хангалуун амьдрахыг бэлгэдсэн зан үйлийн нэг юм[Nangnang 2001, 96].

орохоор нүхтэй буган хэлбэрийн ваар заавал байдаг онцлогтой. Дуурлиг нарсны 2-р булшнаас олдсон ийм том хэмжээний ваарны ёроолоос дээх нь байх нүхэнд модон бөглөө сайн хадгалагдан үлдсэн байв (Дуурлиг нарс 2009, 64). Хүннүгийн язгууртны булшнаас олдсон чий будагтай эдлэлүүд нь бүгд Хан хийцийнх бөгөөд дийлэнхи нь хоёр чихтэй аяганууд юм. Ноён уулын 5-р, 6-р, 20-р булшнаас одоогийн Сычуань мужид байсан хааны шууд харъяаллын үйлдвэрт хийсэн өөд өөдөөс харан сууж буй шувууны дүрстэй, ёроолдоо ханзаар бичсэн бичээс бүхий маш сайн хадгалалттай хоёр чихтэй аяганууд олдож байсан бол Ноён уулын 23-р булшнаас бичээсгүй ургамлын дүрст хээтэй аяга олджээ [Доржсүрэн 1961, 65; Chistyakova 2009, 65]. Мөн Ноён уулын 25-р булшнаас амьтны дүрст хээтэй чий будагтай дугуй сав [Umehara 1960, 33], Дуурлиг нарсны 2-р булшнаас улаан дэвсгэр дээр хар будгаар хээ тавьсан дөрвөлжин хэлбэрийн чий будагтай сав зэрэг ховор содон чий будагтай эдлэлүүд илэрсэн боловч маш муу хадгалалттай байна.

Язгууртны булшинд тахилын идээ ундаа хийсэн сав суулганаас гадна олон төрлийн хүрэл сав, тогоо, цар, гүц мөн хүрэл толь зэргийг зориуд эвдэн, хага цохиж хийсэн байдаг. Тухайлбал, Дуурлиг нарсны 2-р булшны модон хашлагын өмнөд хананы гадна талаас дугуй хэлбэрийн хүрэл цар, гоёмсог хийцийн хүрэл гүц, “TLV” хэлбэрийн хүрэл толь зэрэг зориуд хага цохьсон сав суулгын зүйлс олдсон. Эдгээрийг хага цохисноос гадна галд шатаасныг илтгэх хайлсан хүрлийн үлдэгдэл ч хамт олдсон бөгөөд модон хашлагын орчимд гал түлсэн ул мөр мэдэгдээгүй тул уг эд зүйлсийг нүхнээс гадна хага цохиж галд шатаагаад дараа нь булшинд хийснийг харуулна [Эрэгзэн 2009, 227]. Бусад язгууртны булшнуудад ч үүнтэй төстэй зан үйлийн ул мөр ажиглагджээ. Жишээлбэл, Ноён уулын 6-р булшнаас хага цохьсон хүрэл тогооны ёроол, бариулын хэсэг, Ноён уулын 25-р булшнаас хүрэл толины хагархай [Руденко 1962, таб 7, рис 65], Гол модны 1-р булшнаас олон хэсэг хагарсан хүрэл цар, хүрэл гүцны цорго, хүрэл толины хагархай [Эрдэнэбаатар, Ерөөл-Эрдэнэ 2001], Гол модны 20-р булшнаас хагарсан хүрэл гүцний бөөрний хэсэг, цорго, эвдэрсэн дөрвөлжин төмөр цар, хүрэл толины хагархай, хүрэл тогооны бөөрний хэсэг [Ерөөл-Эрдэнэ, Гантулга 2008, 159], Тахилтын хотгорын 2-р булшнаас олон хэсэг бутарсан гоёмсог хийцийн хүрэл гүц [Наваан 1999, 27] зэрэг олдож байсан байна.

Хүннүгийн язгууртны булшнаас хамгийн түгээмэл илрэх олдвор нь адууны тоног хэрэгсэл юм. Харин язгууртны булшнууд дундаас Ноён уулын 24-р, Тахилтын хотгорын 64-р булшнаас

адууны тоног хэрэгсэл олдоогүй бөгөөд энэ нь уг булшнууд эмэгтэй хүний оршуулга байсантай холбоотой бололтой. Адууны тоног хэрэгсэл нь давхар хашлагатай булшны хувьд 2 хашлагын хоорондох гудамнаас, дан хашлагатай булшинд хашлагын зүүн, эсвэл баруун хананы гадна талаас олджээ. Адууны тоног хэрэгслийг хазаарын болон эмээлийн бүрдэл хэсгүүд хэмээн ерөнхийд нь 2 хувааж болох ба хазаарын бүрдэл нь амгай, зуузай, товруу, холбогч цагираг, арал, духавч зэрэг, эмээлийн бүрдэл нь эмээл, худрага хөмөлдөрөгний чимгүүдийг хэлж буй юм. Амгайн хувьд бүгд нарийн төмрийг битүү гогцоо гарган хийсэн энгийн хийцтэй бөгөөд жирийн жижиг булшнаас гардаг амгайнаас ялгарах зүйлгүй, зөвхөн тоо нь харьцангуй олон байжээ. Харин хазаарын бусад бүрдэл хэсгүүд, ялангуяа товруу, арал, духавч, зуузай зэрэг нь ур хийц сайтай гоёмсог болсны дээр харьцангуй олон төрөл байна. Жишээлбэл, язгууртны булшнаас хоёр үзүүрийг нь сүх хэлбэрээр давтсан төмөр зуузайнаас гадна жирийн булшнаас тэр бүрий гарч байгаагүй үзүүрийг дугуй хэлбэртэй болгосон зуузай олддог. Ильмын амны 54-р булшнаас олдсон үзүүрийг дугуй хэлбэртэй болгосон төмөр зуузайг алтаар бүрсэн байв [Kononov 2008, Pl 33]. Язгууртны булшнаас голчлон алт шармал хүрэл товруу олдох бөгөөд алт шармал төмөр товруу ч гарчээ. Духавч нь голчлон язгууртны булшнаас олдох ба хүрэл, төмөр 2 янз байна. Ноён уулын 25-р булшнаас завь хэлбэртэй хээгүй алт шармал хүрэл духавч [Umehara 1960, Pl 79] олдсон бол Ноён уулын 20-р булшнаас цоолборлосон хээтэй алт шармал төмөр духавч [Цэвээндорж нар 2007, 303], Ильмын амны 54-р булшнаас нимгэн алтаар бүрсэн төмөр духавч [Kononov 2008, Pl 34], Дуурлиг нарсны 2-р булшнаас энгийн хийцтэй төмөр духавч [Дуурлиг нарс 2009, 38] илэрчээ.

Эмээлийн үлдэгдэл зөвхөн Ноён уулын 6-р булшнаас олдсон бол эмээлийн бүрдэл болох худрага, хөмөлдөрөгний мөнгөн чимгүүд харьцангуй том булшнуудаас илэрчээ. Эдгээр худрага, хөмөлдөрөгний мөнгөн чимгүүд нь маш гоёмсог хийцтэй юм. Ерөнхийдөө дугуй болон навч хэлбэртэй агаад дугуйг худрага, навч хэлбэртэйг хөмөлдөрөгний суранд бэхлэх чимэг хэмээн үздэг. Мөнгөн чимгүүд дээр бэлгэт гөрөөс, сарлаг, янгир, буга, лууны дүрсийг хөөлгөн урласан байна. Гол модны 20-р булшнаас бэлгэт гөрөөс [Ерөөл-Эрдэнэ 2007, 249], Ноён уулын 20-р булшнаас бэлгэт гөрөөс, янгир, луу [Цэвээндорж нар 2007, 293], Ноён уулын 6-р булшнаас сарлаг, буга [Руденко 1962, таб 36, 37], Царамын 7-р булшнаас янгирын дүрс бүхий мөнгөн чимэг [Miniaev, Sakharovskaia 2007, 53] олджээ. Гол мод-II дурсгалын 1-р булшнаас бэлгэт гөрөөсийн дүрст хударга, хөмөлдөрөгний мөнгөн чимэг 4 иж, ирвэсийн толгойт ганц эвэрт

домгийн амьтны дүрст хударга, хөмөлдөргөний алтан чимэг 2 иж олдсон [Эрдэнэбаатар нар 2015, 140] нь ур хийцийн хувьд дахин давтагдашгүй гайхамшигтай олдвор юм.

Булшнаас олддог нэгэн өвөрмөц олдвор нь дэнгийн цөгц. Хийсэн материалаас хамаарч шавар, хүрэл хэмээн 2 хуваах боломжтой юм. Шавар цөгц нь хавтгай ёроолтой, ташуу ханатай таваг хэлбэртэй бөгөөд Тахилтын хотгорын 1-р [Наваан 1999, 22], 64-р [Баярсайхан, Эгиймаа 2008, 189], Ильмийн амны 54-р булш [Kononov 2008, Pl 39]-наас олджээ. Хүрэл цөгц нь дугуй хэлбэрийн эх биений хажуу бөөрөнд урт бариултай, 3 жижиг хөлтэй бөгөөд Дуурлиг нарсны 2-р [Дуурлиг нарс 2009, 79], Ноён уулын 25-р булш [Руденко 1962, таб 7]-наас олдсон байна.

Дээрх олдворуудаас гадна Ноён уулын 6-р булшнаас 2 төрлийн дээл, өмд, малгай зэрэг торго бөсөөр хийсэн хувцас өмсгөл [Руденко 1962, таб 10-11, 15-17], Царамын 7-р булшнаас нялх хүүхдийн толгойн ясаар хийсэн оршуулгын хүүхэлдэй [Miniaev, Sakharovskaia 2007, 51-52], Гол модны 20-р булшнаас хөлөгт тоглоом [Ерөөл-Эрдэнэ 2007-1] зэрэг ховор сонин олдворууд ч илэрч олджээ.

IV. Хүннүгийн язгууртны булшны бүтэц ба олдворын харьцуулалт

Дээр өгүүлсэнчлэн Хүннүгийн язгууртны булшны оршуулгын хэсэгт дүнзээр зааж хийсэн модон хашлага (бунхан) байрлах бөгөөд энэ нь дан болон давхар 2 янз байна. Дан модон хашлага Тахилтын хотгорын 1-р, 2-р, 64-р булш, Гол модны 79-р булш, Дуурлиг нарсны 2-р, 5-р булшнаас илэрчээ. Эдгээр булшнаас илэрсэн дан модон хашлагаас хамгийн том нь Тахилтын хотгорын 1-р булшных агаад энэ булшны дүнзэн хашлага 4 м урт, 1.8 м өргөн юм. Тахилтын хотгорын 2-р булшных 3.4 м урт, 1.5 м өргөн [Наваан 1999, 17, 24], Дуурлиг нарсны 2-р булшных 3.6 м урт, 1.9 м өргөн [Эрэгзэн нар 2008, 159], 5-р булшных 3.5 урт, 1.5 м өргөн [Эрэгзэн нар 2009], Гол модны 79-р булшны модон хашлага 3 м урт, 1.7 м өргөн [Эрдэнэбаатар, Ерөөл-Эрдэнэ 2001] хэмжээтэй байна. Харин хамгийн жижиг хэмжээтэй хашлага нь Тахилтын хотгорын 64-р булшных бөгөөд 2.6 м урт 1.2 м өргөнтэй ажээ [Баярсайхан, Эгиймаа 2008, 188]. Тахилтын хотгорын 1, 2-р булшны нүх 11-12 м гүнтэй бол Дуурлиг нарсны 2-р, 5-р булш, Гол модны 79-р,

Ноён ууланд Доржсүрэнгийн малтсан булшны нүх дундажаар 7-8 м гүн байжээ. Гэтэл 2.6 м урт, 1.2 м өргөн хэмжээтэй харьцангуй жижиг дан модон хашлага бүхий Тахилтын хотгорын 64-р булшны нүхний гүн 5.2 м байна. Энэ нь хашлагын хэмжээ томроход нүхний гүн даган нэмэгдэж буйг харуулах ба гадаад байгууламжийн хэмжээ ч хашлага болон нүхний гүнтэй шууд хамааралтай байгаа нь тодорхой ажиглагдана. Тухайлбал, Тахилтын хотгорын 1, 2-р булшны гадаад байгууламж 16х13 м, Дуурлиг нарсны 2-р булшных 11х9 м, Гол модны 79-р булшных 12х10 м хэмжээтэй байхад Тахилтын хотгорын 64-р булшных 8.27х7.8 м хэмжээтэй байна.

Давхар модон хашлага Ноён уулын 1-р, 6-р, 20-р, 22-р, 31-р, 23-р, 24-р, 25-р булш, мөн Баллодын, Кондратьевын, Симуковын булш [Руденко 1962; Доржсүрэн 1961; Цэвээндорж нар 2007], Гол модны 1-р, 20-р булш [Эрдэнэбаатар, Ерөөл-Эрдэнэ 2001; Ерөөл-Эрдэнэ, Гантулга 2008], Царамын 7-р булш [Miniaev, Sakharovskaia 2006], Ильмын амны 54-р булш [Kononov 2008]-наас илэрчээ. Эдгээр булшнууд дунд хамгийн том нь Гол мод-II дурсгалт газарт малтсан 1-р булш, Ноён уулын дурсгалт газарт Баллодын малтсан булш, Царамд малтсан 7-р булш, Гол модны 1-р болон 20-р булш зэрэг юм. Энэ булшнууд 35 м хүртлэх том хэмжээтэй үүдэвтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтайгаас гадна 16-22 м гүн ухсан нүхтэй байжээ. Үүний дараа орох булшнууд нь Ноён уулын дурсгалт газарт Кондратьевын малтсан булш болон тус дурсгалт газрын 6-р булш юм. Кондратьевын малтсан булш 26х26 м, 6-р булш 24.5х24.5 м хэмжээтэй гадаад байгууламжтай бөгөөд нүхний гүн нь 11.3 м хүрчээ. Ильмын амны 54-р булш, Ноён уулын 1-р, 23-р булш, тус дурсгалт газарт Симуковын малтсан булшны гадаад байгууламжийн гол хэсгийн урт 21.9-17 м, өргөн нь 21.9-15 м бөгөөд нүхний гүн нь 10 м орчим байна. Харин давхар модон хашлага илэрсэн булшнууд дунд хамгийн жижиг нь Ноён уулын 24-р булш юм. Уг булшны гадаад байгууламж 16х14 м хэмжээтэй, нүхний гүн 9 м болжээ. Эндээс харахад давхар модон хашлага илэрсэн булшнуудынх ч мөн адилаар гадаад байгууламжийн хэмжээ томрох тусам нүхний гүн даган нэмэгдэж гадаад байгууламж болон нүхний гүн шууд хамааралтай нь тодорхой ажиглагдана.

Мөн модон хашлагын хэмжээ ч гадаад байгууламжийн хэмжээ болон нүхний гүнтэй шууд хамааралтай байна. Жишээлбэл, Баллодын булшны гадаад модон хашлагын хэмжээ 5.87х3.8 м, Гол модны 1-р булшных 5.4х4.4 м, Ноён ууланд Кондратьевын малтсан

булшных 5.32x3.71 м, Ноён уулын 6-р булшных 5.34x3.99 м, Ноён уулын 1-р булшных 4.61x2.9 м, Ноён уулын 23-р булшных 4.31x3 м байх ба хамгийн жижиг болох Ноён уулын 24-р булшных 4.1x2.7 м хэмжээтэй ажээ (1-р хүснэгт).

Хүснэгтээс тодорхой харагдаж байгаачлан Хүннүгийн язгууртны булшнуудын оршуулгын хэсэгт байрлах модон хашлагын хэмжээ, нүхний гүн, газрын өнгөн хөрсөн дээр ил байрлах гадаад байгууламжийн хэмжээ гэсэн үндсэн үзүүлэлтүүд хоорондоо шууд уялдаа холбоотой байна. Түүнээс гадна нэг сонирхолтой зүй тогтол ажиглагдсан нь гадаад байгууламжийн хананы урт 16 м хүртэлх харьцангуй жижиг булшнуудаас дан модон хашлага, түүнээс том гадаад байгууламжтай булшнаас давхар модон хашлага илэрчээ. Мөн гадаад байгууламж 10 метрээс дээшх булшнуудаас илэрсэн дан модон хашлагын урт 3 метрээс урт болсон бол эсрэгээр гадаад байгууламжийн хэмжээ 10 метрээс бага булшны модон хашлагын урт 3 метрээс богино байна. Үүнтэй адилаар давхар хашлагатай булшны модон хашлагын уртын хэмжээг баримтлан 4-5 м ба 5 метрээс дээш хэмжээтэй хэмээн 2 хувааж болох бөгөөд 4-5 м хэмжээтэй жижиг нь 16-23 м хэмжээтэй гадаад байгууламжит булшнаас, 5 метрээс дээш хэмжээтэй том хашлага нь 24-35 м хүртлэх том хэмжээтэй гадаад байгууламжит булшнаас илэрчээ.

Хүннүгийн язгууртны булшны гадаад, дотоод байгууламж дээрхийн адил хоорондоо уялдаатай байхаас гадна илэрсэн олдворууд ч булшны бүтэцтэй холбоотой өөрчлөгдөх тал ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл хамгийн том булшнаас олон тоотой, ур хийц сайтай гоёмсог эд зүйлс, жижиг булшнаас түүнээс цөөн тоотой, ур хийцийн хувьд дутуу эд зүйлс олдох зүй тогтол харагдаж байна. Үүнийг хамгийн тодорхой үзүүлэх баримт нь авсны гадна талд хадсан байдаг авсны төмөрлөг чимгүүд юм. Жишээлбэл, малтлага хийсэн булшнууд дунд хамгийн жижигт тооцогдох Тахилтын хотгорын 64-р булшны авсны гадна талд 1-1.5 см өргөнтэй төмөр туузыг ханалан хадаж, түүний нүднүүдэд 3 болон 4 дэлбээт цэцгэн чимгийг тогтоосон байжээ [Баярсайхан, Эгиймаа 2008, 188-189, 8-р зураг]. Үүнээс ялимгүй том хэмжээтэй булш болох Дуурлиг нарсны 5-р булшнаас алт шармал хүрэл цэцгэн чимэг олдсон байна [Эрэгзэн нар 2009]. Тэгвэл эдгээрээс том хэмжээтэй Гол модны 79-р булшны авсыг 1 см өргөнтэй мөнгөн туузаар даруулан хадаж, нүднүүдэд 4 дэлбээтэй алтан чимгийг төмөр хадаасаар тогтоосон [Эрдэнэбаатар, Ерөөл-Эрдэнэ 2001] бол Дуурлиг нарсны 2-р булшинд авсны чимгийг бүгдийг нимгэн алтаар хийсэн байлаа

[Эрэгзэн нар 2008, 159]. Давхар хашлагатай булшнаас илэрсэн авсны ийм чимгүүд нь бүгд алтаар хийгджээ. Гэхдээ товгор хөөмөл хээтэй, бүр чулуун шигтгээтэй зэрэг илүү гоёмсог болсон байна. Жишээлбэл, Ноён уулын 6-р булшны алтан чимгэнд товойлгон хээ гаргаж, модон суурьтай үйлдсэн [Руденко 1962, таб 34] бол Гол модны 20-р булшнаас олдсон авсны цэцгэн хэлбэрт алтан чимгийг товгор хээтэйн дээр хээний хоорондох зайд оюу шигтгээ суулган маш гоёмсогоор урлажээ [Ерөөл-Эрдэнэ, Гантулга 2008, 162].

Дээрх зүй тогтол өөр бусад олдворуудад ч ажиглагддаг. Тахилтын хотгорын 64-р, Дуурлиг нарсны 5-р булш зэрэг харьцангуй жижиг язгууртны булшнуудад тэрэг дагалдуулаагүй байхад үүнээс хэмжээгээр том булшнуудад тэрэг дагалдуулсан байжээ. Харин дагалдуулан тавьсан тэрэг нь булшны хэмжээнээс хамаарч ур хийцээр ялгаатай болж байна. Жишээлбэл, Гол мод-II дурсгалын 1-р булшнаас олдсон бүтэн тэрэг нь улаан, цагаан, хар өнгө хослосон гоёмсог үүлэн хээтэй, алт шармал төмөрлөг тоногтой байсан ба 15-17 ш тэрэгний эд ангийг зориуд эвдэн дагалдуулан тавьсан байжээ [Эрдэнэбаатар нар 2015, 116]. Ноён уулын Кондратьевын булш болон 20, 25-р, Гол модны 20-р булш, Царамын 7-р булш зэрэг гол байгууламж 20 м-с дээш урттай том булшнаас олдсон тэрэгний шүхрийн хүрэл дог нь өлгүүр мэт сэртэнгийн дор үе гаргасан мэт товгор хээтэй, тэрэгний тэвш хүрэл тоногтой, зарим хэсэгт сийлбэртэй, тэрэгний дугуйн булны тагийг хүрлээр хийж алтаар шармалдсан байхад жижгэвтэр хэмжээтэй Дуурлиг нарсны 2-р, Тахилтын хотгорын 1-р булшны шүхрийн хүрэл дог энгийн цулгуй хийцтэй, тэрэгний тэвшинд хүрэл тоног, сийлбэр байхгүй, булны тагийг төмрөөр хийсэн байгаа нь давхар модон хашлагат булшнаас олдсон тэрэг дан модон хашлагатай булшнаас илэрсэн тэрэгнээс харьцангуй гоёмсог хийцтэй, мөн хэмжээгээр том болохыг харуулж байгаа юм. Тахилтын хотгорын 1-р булш, Дуурлиг нарсны 2-р булшнаас илэрсэн хүрэл царны бариулын цагирагийг нарийн гогцоогоор бэхэлсэн бол Гол модны 1, 20-р булшнаас илэрсэн царны бариулын цагираг домгийн амьтны дүрст суурьтай байх бөгөөд дээрхи булшнуудаас илэрсэн хүрэл гүцнүүдэд ч энэ байдал давтагдаж байна.

Энэ бүхнээс үзэхэд Хүннүгийн язгууртны булшнуудын бүтэц зохион байгуулалт, хэлбэр нь хоорондоо төстэй, дагалдуулан тавьсан олдворууд ч төрөл, хэлбэрийн хувьд ойролцоо байх ба зөвхөн хэмжээнээс хамаарч дотоод байгууламжид өөрчлөлт гарч, олдворын тоо, хийц ялгаатай болж байгаа нь тодорхой байна.

V. Хүннүгийн язгууртны булшны холбогдох он цаг

Монгол болон ОХУ-ын Өвөр Байгалд малтлага судалгаа хийсэн Хүннүгийн язгууртны булшнаас үйлдсэн газар, хийсэн хүн болон цаг хугацааны тухай мэдээлэл агуулсан бичээстэй өмнө зүгийн гаралтай чий будагтай эдлэл, дээрх дүрслэл хийц зэргийг харьцуулан үйлдвэрлэгдсэн цаг хугацааг тогтоох боломжтой хүрэл толь, ханз үсэгтэй торго нэхмэл зэрэг булшийг байгуулсан он цагийг баримжаалахад чухал хэрэгтэй олдвор эд өлгийн зүйлс цөөнгүй олджээ. Жишээлбэл, Ноён уулын 6-р булшнаас амсарын 2 талд чих маягийн бариултай чий будагтай аяга олдсон бөгөөд түүний ёроолд “上林” гэсэн 2 ханз үсгийг нарийн үзүүртэй зүйлээр сийлсэн агаад ёроолын гадна талын хүрээг дагуулан бичсэн 17 үсэг бүхий “建平五年九月 工王 潭經 畫工獲壺 天武省” ийм бичээс байна. Мөн энэ дурсгалт газарт Симуковын малтсан булшнаас “建平五年 蜀郡西工,....” гэсэн 67 үсэг бүхий бичээстэй чий будагтай аяга олджээ. Бичээснээс үзвэл 2 аягыг хоёуланг нь Цяньпингийн 5-р он (НТӨ 2 он)-д үйлдсэн нь мэдэгдэх бөгөөд Н.В.Бернштам бичээсийг баримтлан 6-р булшнаас илэрсэн аягыг Үжүли-жоди шаньюйг Хан улсын хааны Шанлиньюан ордонд айлчлахад бэлэг болгосон зүйл хэмээн тайлбарлаад уг булшийг МЭ 13 онд нас нөхсөн тэрхүү шаньюйн булш хэмээн үзсэн байдаг. Харин Ц.Доржсүрэн бусад эдийн боловсролын зүйлсийг харгалзан үзээд 6-р булшийг НТӨ I зуунаас МЭ I зуунд холбогдоно хэмээн тайлбарлажээ [Доржсүрэн 1961, 59-62]. 2006 онд малтлага хийсэн Ноён уулын 20-р булшнаас 3 ш чий будагтай аяга олдсон бөгөөд үүний 1 аяганы ёроолд 46 үсэг бүхий бичээс байна. Уг бичээсэн дундах “元延四年” гэсэн 4 үсэг нь аягыг НТӨ 9 онд үйлдсэнийг тодорхой хэлж өгч буй юм [Chistyakova 2009, 65]. Эдгээр хэрэглэгдэхүүн нь дээрх 3 булшийг НТӨ 9 он болон НТӨ 2 оноос эрт байгуулаагүйг баталж байна. Гол модны 20-р булшнаас илэрсэн чий будагтай модон тавагны ёроолд 30 ханз үсэг мэдэгдэж байсан бөгөөд түүнд тулгуурлан уг тавгийг НТӨ 16 онд бүтээснийг тогтоосон байна [Ерөөл-Эрдэнэ 2015, 118]. Царамын дурсгалт газрын 7-р булшнаас илэрсэн чий будагтай аяган дээрх бичээсийг тайлж уншсан судлаачид аягыг НТӨ 8-НТ 4 оны үед холбогдоно хэмээн үзсэн байдаг.

Ноён уулын 1-р, 6-р зэрэг хэд хэдэн булшнаас “新神靈廣成壽萬年” ханз үсэгтэй торгоны үлдэгдэл олджээ. Энэ торго нь Баруун Хан улсын төгсгөлд төрийн эргэлт хийж охорхон хугацаанд хятадыг захирсан Ван Маны үед холбогдоно. Энэ мэтчилэн торго болон чий

будагтай эдлэлүүдийн он цаг ерөнхийдөө давхцаж байгаагаас харахад эдгээр булшнууд НТ I зууны үед байгуулагдсан байх магадлал өндөр байгаа юм.

2-р хүснэгт. Хүннүгийн язгууртны булшнаас олдсон он цаг тогтоох хэрэглэгдэхүүн

	Булшны дугаар	Чий будагтай э длэл	Хүрэл толь	Радио-карбон задлан шинжилгээ	Таамаглаж буй он цаг
1	Ноён уул 6-р булш	НТӨ 2 он			НТ I зуун
2	Ноён уул, Симуковын булш	НТӨ 2 он			НТ I зуун
3	Ноён уул, 25-р булш		НТӨ I-НТ I зуун		НТ I зуун
4	Ноён уул, 20-р булш	НТӨ 9 он			НТ I зуун
5	Гол мод, 1-р булш		НТ I зуун	НТ 78-81	НТ I зуун
6	Гол мод, 20-р булш	НТӨ 16 он	НТ I зуун		НТ I зуун
7	Гол мод, 79-р булш			НТ 82	НТ I зуун
8	Дуурлиг нарс, 2-р булш		НТ I зуун		НТ I зуун
9	Ильмын ам, 54-р булш			НТӨ 30-НТ 50	НТ I зуун
10	Царам, 7-р булш	НТӨ 8-НТ 4 он	НТӨ I-НТ I зуун	НТ 30-120	НТ I зуун

Ноён уулын 25-р булш, Гол модны 1-р, 20-р булш, Дуурлиг нарсны 2-р булш, Царамын 7-р булшнаас хүрэл толины хагархай олджээ. Дээрх дүрслэлээс үзвэл Гол модны 20-р болон Дуурлиг нарсны 2-р булшнаас илэрсэн нь судлаачдын дунд “TLV(規矩鏡)” хэлбэрийн хэмээн алдаршсан хүрэл толь, Ноён уулын 25-р, Царамын 7-р булшнаас олдсон нь “四乳四神鏡”, Гол модны 1-р булшнаас гарсан нь “雲雷連弧文鏡”-ны хагархай болох нь төвөггүй танигдана. Хан хийцийн хүрэл толины судалгаанд тулгуурлавал, TLV хэлбэрийн толь нь дээрх дүрслэлээс шалтгаалан四神規矩鏡, 鳥獸規矩鏡, 幾何文規矩鏡, 簡化規矩鏡 гэх мэтээр ангилагдах [孔祥星, 劉一曼 2003, 156-170] бөгөөд Дуурлиг нарсны 2-р болон Гол модны 20-р булшнаас олдсон толины хагархай нь鳥獸規矩鏡 ангилалд багтах боломжтой байна. 鳥獸規矩鏡 нь Зүүн Хан улсын эхэн үед холбогдоно. Ноён уулын 25-р болон Царамын 7-р булшнаас олдсонтой ижил四乳四神鏡 толинууд ч ерөнхийдөө Баруун Хангийн төгсгөл, Зүүн Хангийн эхэн үед холбогддог байна [Эрэгзэн 2009, 185]. Гол модны 1-р булшнаас олдсон толийг Францын судлаачид хятадын хэрэглэгдэхүүнтэй харьцуулан НТ I зууны дунд үед холбогдохыг тогтоожээ [Le preimer...2003, 257]. Эндээс үзвэл хүрэл толь илэрсэн 5 булш ч мөн адил НТ I зуунд холбогдох боломжтой байна.

Сүүлийн жилүүдэд Хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн мод, яс зэрэг органик эдээс дээж авч радио-карбоны аргаар он цаг тогтоох судалгааг харьцангуй сайн хийж байна. Тухайлбал, Дуурлиг нарс, Гол мод, Гол мод-II, Ноён уул, Тахилтын хотгор, Ильмийн ам, Царам зэрэг олон дурсгалт газарт малтлага хийсэн язгууртны булшнууд болон тэдгээрийн дагуул булшнаас дээж авч радио-карбон шинжилгээ хийсэн. 2015 онд Ч.Ерөөл-Эрдэнэ нийт 32 булшнаас авсан радио карбоны үр дүнг нэгтгэн хэвлүүлсэн бөгөөд тэдгээрийн он цаг дийлэнх нь НТӨ I зуунаас НТ I зуунд холбогдохоор гарсан байна [Ерөөл-Эрдэнэ 2015, 122].

Ийнхүү бүтээгдсэн он цаг тодорхой мэдэгдэж буй Хан хийцийн чий будагтай эдлэл, хүрэл толь болон мод, ясны дээжийн радио-карбоны задлан шинжилгээний үр дүнгүүд ерөнхийдөө ойролцоо цаг үед холбогдохоор гарч буй нь Монгол болон Өвөр Байгалд тархсан Хүннүгийн язгууртны булшнуудын дийлэнх НТ I зууны үед байгуулагджээ хэмээн үзэх боломжийг олгож байгаа юм.

VI. Үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн Хүннүгийн язгууртны булш бий болсон нөхцөл ба он цагийн таамаглал

Тус өгүүлэлд дурдан буй Хүннүгийн язгууртны булш гэдэг нэр томьёо нь газрын өнгөн хөрсөн дээр үүдэвч бүхий дөрвөлжин хэлбэрийн хүрээлсэн чулуун байгууламжтай, газрын гүнд шатлан багасгаж ухсан нүхтэй, ёроолд нь дан болон давхар модон хашлага дотор модон авсанд хүнээ оруулсан оршуулгын байгууламжийг авч үзэж байна. Ийм хэлбэр хоорондоо хэдэн зуугаас хэдэн мянган км алслагдсан дурсгалт газруудад малтлага хийсэн булшнуудад нийтлэг ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, Дуурлиг нарсны дурсгал нь Монголын зүүн бүс нутагт байрлах бол Ноён уул, Бэлхийн амны дурсгал нь Монголын төвийн бүс нутагт Улаанбаатар хотын ойролцоо байрлана. Гол мод, Гол мод-II дурсгал нь мөн л Монголын төвийн бүс нутагт Улаанбаатар хотоос баруун тийш 500 орчим км зайд байна. Харин Тахилтын хотгор, Овооно хар зэрэг дурсгалууд нь Монголын баруун бүс нутагт нийслэл хотоос 1000 гаруй км зайд байрлана. Тэгэхээр зүүн захын Дуурлиг нарнаас баруун захын Тахилтын хотгорын дурсгал хүртэл бараг 2000 км алслагдсан байна гэсэн үг. Ийм алс хол байрлах хэдий ч эдгээр дурсгалуудын гадаад хэлбэр болон дотоод бүтэц,

дагалдуулсан эд өлгийн зүйлсэд нийтлэг байдал ажиглагдах ба он цаг нь ч хоорондоо ойролцоо байна гэдэг нь Хүннүгийн үед язгууртнуудыг оршуулахад нэгдсэн хэлбэр, тогтсон ёс хэдий нь бий болсон байсныг харуулдаг.

Хятад сурвалжийн мэдээ баримтаас үзэхэд Хүннү гүрэн НТӨ III зууны төгсгөлөөс НТ I зууны төгсгөл хүртэл 300 илүү жил оршин тогтносон. Хүннү гүрэн эхний үед буюу Модун шаньюйгаас Гүнчен шаньюй хүртлэх 70 гаруй жилийн хугацаанд маш хүчирхэг байж өмнөд хөрш Хан улсаас алба татвар авч, одоогийн Шинжаны нутагт байсан баянбүрд дагасан хот улсуудыг хяналтандаа байлган дорно-өрнийг холбосон худалдааны замаас асар их ашиг олж байжээ. Түүний дараагаар Хан улсад У-ди хаан ширээнд сууснаас хойш өмнөд хөрштэйгээ 40 жил үргэлжилсэн дайн хийж хүч нь тарамдсан ба НТӨ I зууны дунд үед дотоодын хагарлаас болж ихээхэн суларчээ. Улмаар НТӨ 30-аад онд Хүннүгийн Хуханье шаньюй Хан улсаас тусламж авах хэмжээнд хүртэл доройтсон байдаг. Гэхдээ Хан улсад бий болсон төрийн хямралыг далимдуулан Хүннү улс дахин хүчирхэгжиж ирсэн ч НТ I зууны 40-өөд оноос Умард, Өмнөд болон хуваагдаж мөхөх замдаа оржээ.

Түүхэн сурвалжийн он тоололтой харьцуулан үзвэл бидний авч хэлэлцэж буй язгууртны булшнууд Хүннү гүрний төгсгөл үед холбогдох нь тодорхой байна. Үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшны нүхийг ухсан байдал зарим талаар Хятадын Хан улсын үе болон түүнээс өмнөх Цин улсын үеийн булшнуудтай төстэй байдал ажиглагддаг. Тиймээс судлаачид Хүннүгийн язгууртны булшинд Хан улсын соёлын нөлөө туссан хэмээн үздэг бөгөөд язгууртны булшнаас илэрдэг чий будагтай сав суулга, хүрэл толь, чий будагтай сүйх тэрэг зэрэг олон тооны хятад хийцийн олдворыг нотолгоо болгон авч үзсээр ирсэн. Гэхдээ булшны бүтэц зохион байгуулалтын онцлогийг нарийн ажиглахад үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшны дотоод байгууламж буюу модон хашлагын хэлбэр, оршуулгын зан үйлийн ул мөр нь өмнөх үеийн уламжлалыг илүүтэй хадгалсан шинжтэй, булшны нүхийг ухсан арга барил, хэлбэр нь Хан улсын нөлөө туссан байдалтай ба гадаад байгууламж нь огт шинээр бий болсон зүйл болох нь мэдэгддэг. Олдвор эд зүйлсийн хувьд ч дан Хятад зүйлс голлодог бус Дундад Ази, Грек-Бактри, Ром, Египетээс ирсэн харь гаралтай зүйлс, мөн өөрсдийн дотоодын бүтээгдэхүүн зэргийг хослуулсан олон талтай болох нь нэгэнт тодорхой болжээ. Энэ байдал нь Хүннүгийн язгууртнууд тухайн цаг үедээ дэлхийн голлох улс гүрнүүдтэй өргөн харилцаатай, гадаадын дэвшилттэй зүйлсийг авч

ашиглаж чаддаг, олон соёлын уулзвар дээр өөрсдийн соёлыг бий болгон хөгжүүлж байсныг харуулдаг.

Энд анхаарал татаж буй зүйл нь үүдэвчтэй дөрөлжин хэлбэрийн асар том хэмжээтэй булшнууд яагаад Хүннү гүрний төгсгөлийн шатанд бий болсон ба ийм булшнууд гарч ирэх болсон нөхцөл байдлын асуудал юм. Хөгжлийн зүй тогтол талаас үзвэл асар том хэмжээтэй булш хамгийн хүчирхэг байх цаг үед хийгдсэн байх учиртай. Үүний шалтгааныг тайлах хэд хэдэн сурвалжийн мэдээ баримт бий. Одоогоор малтлага судалгаа хийсэн Хүннүгийн язгууртны булшнууд дотор эрт цагт тонуулчид сүйтгээгүй булш нэг ч байхгүй байна. Түүнээс гадна малтлага хийгээгүй булшнууд ч эрт цагт тоногдож сүйтгэгдсэн болох нь гадаад байдлаас мэдэгддэг. “Хан улсын бичиг”-т Хүннүгийн шаньюй нарын булшийг ухуаньчууд тонож сүйтгэсэн талаарх мэдээ баримт бий. Энэ явдал хүннүгийн шаньюйн орд говийн хойно гарсан үеэс хойш буюу НТӨ I зууны эхэн хагаст болжээ [Эрэгзэн 2009]. Тэгэхээр язгууртны булшийг тонож сүйтгэх явдал хүннүчүүдийн хувьд анхааралдаа авахаас аргагүй чухал асуудал болсон төдийгүй тонуулчдаас сэргийлэх арга эрэлхийлэхэд хүргэсэн бололтой. Хүннүгийн язгууртны булшнууд асар гүнзгий нүхтэй байдаг нь тонуулчдаас сэргийлэх нэг арга байсан нь малтлагын явцад мэдэгддэг. Түүнчлэн булшны нүхийг булахдаа олон үе чулуун чигжээс хийсэн байдаг нь ч тонуулчдаас сэргийлэх арга байсан бололтой. Одоогоор мэдэгдэж буй хамгийн гүн нүхтэй булш Гол мод-II дурсгалт газарт малтлага хийсэн 1-р булш бөгөөд нүхний гүн 22 м хүрсэн бол Гол модны 20-р булшных 18 м, Ноён уулын 20-р булшны нүх 18.3 м гүн байв. Ийм гүнзгий нүхийг ухахын тулд хөрсний нуралт, шороо чулуу зөөх нөхцөл зэрэг олон талын тооцоо шаардлагатай болно. Өөрөөр хэлбэл инженерийн тооцоолол хэрэгтэй юм. Хүннүчүүдийн хувьд барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхэд олзны болон дагаж орсон хятад зэрэг суурин иргэдийг ихээр ашигладаг байсан тул тэднээр хийлгэсэн байх магадлал өндөр. Дээр дурдсанчлан Хүннүгийн язгууртны булшны нүхний хэлбэр, ухсан арга барил Хятадын Цин, Хан улсын том булшнуудынхтай төстэй байдгийн шалтгаан үүнтэй холбоотой болов уу хэмээн таамаглаж байна.

Нэг сонирхолтой зүйл нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшнууд ихэвчлэн элсэрхэг хөрстэй газарт байрлана. Зөвхөн Ноён уул болон Бэлхийн амны булшнууд хатуу чулуурхаг хөрстэй газарт бий. Өөр нэг онцлог нь элсэрхэг хөрстэй газрын булшнууд

уулын арын тэгш дэвсэг газарт байрлах бол Ноён уул, Бэлхийн амны булшнууд уулын энгэр талд байрладгаар ялгаатай. Хүннүгийн цагариг хэлбэрийн жижиг булшнууд бүгд уулын энгэр талд байрлах бөгөөд энэ шинжээр Ноён уул, Бэлхийн амны язгууртны булшнуудын байрлал зүй илүү уламжлалаа хадгалсан байрлалтай ажээ.

Бэлхийн амны дурсгалт газарт энэ жил малтлага судалгаа хийсэн бөгөөд одоогоор он цагийн нарийвчилсан шинжилгээний хариу хараахан гараагүй байгаа бол Ноён уулын дурсгалт газарт малтлага хийсэн булшнуудын он цаг илүү тодорхой болсон. Ноён уулын дурсгалаас илэрдэг чий будагтай Хан хийцийн сав суулга, торго нэхмэл зэрэг үйлдвэрлэсэн он цагийг мэдэх боломжтой олдворууд бүгд НТӨ I зууны төгсгөл, НТ I зууны эхэн хагаст холбогддог. Радио-карбон шинжилгээний дүн ч үүнийг давхар нотлодог юм. Үүнээс үзэхэд Ноён уулын булшнууд үүдэвчтэй дөрвөлжин хэлбэртэй язгууртны булшнууд дотор хамгийн эрт үед холбогдох боломжтой. Газар сонголтын онцогоос харахад үүдэвчтэй том булшнуудыг анх Ноён уул, Бэлхийн ам зэрэг газруудад байгуулсан байх магадлал их. Малтлага судалгааны явцад хийсэн ажиглалтаар ч энэ нь илүү мэдэгддэг. Ноён уул, Бэлхийн амны хөрс маш их чулуутай, хатуу бөгөөд гүнзгий ухахад их хүндрэлтэй байдаг. Түүнтэй харьцуулахад Дуурлиг нарс, Гол мод, Гол мод-II зэрэг дурсгалт газрын булшнууд элсэн хөрстэй газарт байрлах бөгөөд хөрсний онцлогоос харахад гүнзгий ухахад хүндрэл нь харьцангуй бага юм. Эндээс үзэхэд хүннүчүүд үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гүнзгий нүхтэй булшнуудыг анх Ноён уул, Бэлхийн ам зэрэг газруудад байгуулсан бөгөөд ингэхдээ газар сонголтын уламжлалаа илүүтэй баримтлаж уулын энгэр талд оршуулга хийж байсан бололтой. Харин уулын энгэр газар нь чулуу ихтэй, хатуу хөрстэй байх тул хожим нь илүү хялбар ухах боломжтой элсэрхэг хөрстэй уулын арын тэгш газрыг сонгодог болсон хэмээн таамаглаж болох бөгөөд үүнийг дурсгалт газруудын булшны холбогдох он цаг илүү бататгаж өгч байна.

Ноён уулын дурсгалыг анх илэрсэн цагаас эхлэн хятад гаралтай Хан хийцийн чий будагтай олдворуудын бичээс, торго нэхмэл дээрх бичээс зэрэгт тулгуурлан Хуханье шаньюйн удмынхны булш оршуулга хэмээн үзэж ирсэн. Хуханье шаньюй НТӨ 33 онд Хан улсад айлчилж, түшмэг улс болох гэрээ байгуулж, Хан улсын хааны ордны гүнжийг буулган авсан бөгөөд түүний удмын шаньюй нар Ван Маны үе хүртэл Хан улсад айлчлал хийж, хятад гүнж авч байсан төдийгүй Хан улсаас их хэмжээний бэлэг шан харамж

хүртгэж байсан талаар сурвалжийн мэдээ баримт их бий. Энэ үеэс Хүннү гүрэнд Хан улсын нөлөө илүүтэй нэмэгдсэн нь тодорхой бөгөөд энэ нь булш оршуулгын бүтэц хэлбэрт нөлөөлсөн байх магадлал өндөр юм. Ноён уулын булшнууд үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булшны хамгийн эрт үед холбогдохоор тогтоогдож буй тул Хуханье шаньюйн үеэс үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булшийг хүннүчүүд байгуулж эхэлсэн хэмээн таамаглаж байна.

